




# НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ













2020/08

ᠨᠠᠯᠠᠶᠢᠬᠡ ᠳᠦᠦᠷᠭᠢ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ ᠰᠠᠲᠢᠰᠲᠢᠻᠢᠬᠢ ᠬᠡᠯᠲᠤᠰ



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2014-2018 ОН	2-3
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	4
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	5-6
 НИЙГМИЙН ДААТГАЛ	7-8
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	8-9
 ЭРҮҮЛ МЭНД	9-11
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	11
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	12
 ГЭМТ ХЭРЭГ	12-13
 ТӨСӨВ	13
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	14-15
 АЖ ҮЙЛДВЭР	15-16
 ХАРИЛЦАА ХОЛБОО	16-17
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	17-18



## ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2020
Суурин хүн ам, жилийн эцэст	тоо	36 425	36 911	37608	37715	-
Ажилгүйчүүд, сарын эцэст	тоо	1 015	192	227	233	258
Үүнээс: эмэгтэй	тоо	557	113	116	111	126
Шинээр төрсөн хүүхэд	тоо	591	532	583	555	616
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	707	340	306	286	283
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	342	298	313	238	251
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	11 186.1	11 130.8	12 199.2	15 075.9	23 331.9
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	11 054.7	10 514.3	11 185.1	13 906.7	24 021.3

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны VIII сард				2020 оны VIII сард					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
<b>Хүн амын нягтрал</b> /нэг кв км-т ногдох хүн/	тоо	311	Баянгол	7 791	Налайх	55	317	Баянгол	7 734	Налайх	55
			Чингэлтэй	1 783	Багануур	48		Чингэлтэй	1 712	Багануур	47
			Сүхбаатар	704	Багахангай	32		Сүхбаатар	704	Багахангай	32
<b>Ажилгүйчүүд</b> хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	79	Багахангай	591	Хан-Уул	70	49	Багахангай	601	Баянзүрх	44
			Багануур	148	Баянгол	59		Багануур	173	Чингэлтэй	38
			Баянзүрх	111	Сонгинохайрхан	39		Баянгол	73	Сонгинохайрхан	27
<b>Нялхсын нас баралт</b> /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	10	Налайх	14	Сүхбаатар	8	11	Сонгинохайрхан	12	Хан-Уул	5
			Багануур	12	Хан-Уул	7		Налайх	12	Сүхбаатар	3
			Чингэлтэй	12	Багахангай	-		Баянгол	9	Багахангай	-
10 000 хүн тутмаас <b>халдварт өвчнөөр</b> <b>өвчлөгчид</b>	0\000	112	Баянзүрх	135	Баянгол	86	76	Налайх	75	Сүхбаатар	45
			Сонгинохайрхан	98	Налайх	77		Багануур	69	Хан-Уул	41
			Хан-Уул	93	Багахангай	9		Сонгинохайрхан	67	Багахангай	21
<b>Төсвийн орлого,</b> <b>зарлагын харьцаа</b> зарлага=100	тоо	76	Сүхбаатар	79	Налайх	13	66	Чингэлтэй	64	Багануур	11
			Чингэлтэй	66	Багануур	10		Сүхбаатар	56	Налайх	10
			Хан-Уул	56	Багахангай	6		Хан-Уул	42	Багахангай	7
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох <b>Гэмт хэрэг</b>	тоо	157	Сүхбаатар	245	Налайх	95	119	Сүхбаатар	196	Сонгинохайрхан	79
			Чингэлтэй	176	Багануур	63		Баянзүрх	136	Багахангай	57
			Баянзүрх	171	Багахангай	44		Чингэлтэй	126	Багануур	53

Тайлбар: \* промилль \*\* продицимль

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2020 оны VIII сарын танилцуулга



## ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 258 иргэн байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 хүнээр (10.7%) өссөн ба 48.8 хувь нь эмэгтэйчүүд эзлэж байна.

Бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 21.7 хувь нь 15-24 насны залуучууд, 35.6 хувь нь 25-34 насныхан, 25.6 хувь нь 35-44 насныхан, 14.7 хувь нь 45-54 насны, 2.3 хувь нь 55-59 насныхан байна. Үүнээс 0.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеээс 80 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Дүүргийн ажилгүйчүүд, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2016		2017		2018		2019		2020	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Ажилгүйчүүд	1015	557	192	113	227	116	233	111	258	126
Насны бүлгээр:										
15-24	155	82	62	36	61	29	60	29	56	28
25-34	351	194	79	47	84	52	74	30	92	54
35-44	268	152	38	23	55	26	61	31	66	28
45-54	163	91	10	7	22	9	30	18	38	14
55-59	53	23	3	-	4	-	7	3	6	2
60+	25	15	-	-	1	-	1	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	40	13	4	1	2	-	10	6	2	1

Хүснэгт 4. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн VIII сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо				Дүнд эзлэх хувь			
	2017 VIII	2018 VIII	2019 VIII	2020 VIII	2017 VIII	2018 VIII	2019 VIII	2020 VIII
Ажилгүйчүүд, бүгд	192	227	233	258	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:								
Магистр, доктор	1	3	3	1	0.5	1.3	1.3	0.4
Дипломын болон бакалавр	52	55	38	45	27.1	24.2	16.3	17.4
Тусгай мэргэжлийн дунд	11	14	8	7	5.7	6.2	3.4	2.7
Техникийн болон мэргэжлийн	10	15	19	28	5.2	6.6	8.2	10.9
Бүрэн дунд	97	126	137	148	50.5	55.5	58.8	57.4
Суурь	18	10	17	22	9.4	4.4	7.3	8.5
Бага боловсрол	1	3	4	6	0.5	1.3	1.7	2.3
Боловсролгүй	2	1	7	1	1.1	0.5	3	0.4

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



## ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2020 оны эхний 8 сард шинээр төрсөн 616 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 168 хүнийг бүртгэлээс хасаж, 94 гэрлэлт, 21 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61 хүүхдээр (10.9%), нас баралт өмнөх оны мөн үеэс 13 (8.4%) тус тус өссөн байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 52.4 хувь нь хүү, 47.6 хувь нь охин байна. Нас баралтад 64.3 хувь нь эрэгтэй, 35.7 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

Хүснэгт 5. Төрөлт, нас баралтын бүртгэл, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
Төрсөн хүүхэд, бүгд	591	532	583	555	616
Үүнээс:					
Эрэгтэй	285	301	301	284	323
Эмэгтэй	247	290	282	271	293
Нас баралт, бүгд	170	169	175	155	168
Үүнээс:					
Эрэгтэй	109	106	118	99	108
Эмэгтэй	60	64	57	56	60

Зураг 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт



Хүснэгт 6. Бүртгүүлсэн гэр бүл, насны бүлгээр, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2018 I-VIII			2019 I-VIII			2020 I-VIII		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Нийт	310	155	155	256	128	128	188	94	94
18-19	1	-	1	1	-	1	2	-	2
20-24	69	24	45	47	18	29	37	15	22
25-29	126	67	59	87	45	42	52	27	25
30-34	59	34	25	63	36	27	52	27	25
35-39	15	10	5	22	10	12	18	12	6
40-44	16	8	8	13	6	7	8	4	4
45-49	9	5	4	12	6	6	12	6	6
50+	15	7	8	11	7	4	7	3	4

2020 оны эхний 8 сард гэрлэлтээ баталгаажуулсан 94 хос байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 (26.5%) буурсан байна. Хосуудыг насны бүлгээр нь авч үзвэл 1.1% нь 18-19 насны, 19.7% нь 20-24 насны, 27.6% нь 25-29 насны, 27.6% нь 30-34 насны, 9.6% нь 35-39 насны, 4.3% нь 40-44 насны, 6.4% нь 45-49 насны 3.7% нь 50-аас дээш насныхан байна.

Хүснэгт 7. Гэр бүл цуцлалт, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт		2016 I-VIII	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
Гэр бүл цуцлалт, бүгд		41	35	33	35	21
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	-	3	-	2	1
	1-3	1	5	-	-	2
	4-6	4	5	6	3	-
	7-9	10	5	6	4	-
	10-14	11	11	11	20	13
	15-19	3	3	2	3	3
	20 ба түүнээс дээш	12	3	8	3	2

2020 оны эхний 8 сард нийт 21 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 4.8% нь нэг хүртэл жил, 9.5% нь 1-3 жил, 61.9% нь 10-14 жил, 14.3% нь 15-19 жил, 9.5% нь 20-оос дээш жил хангилсан хосууд байжээ.

Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 хувиар буурсан байна.

Дүүрэгт 2020 оны эхний 8 сард үрчлэгдсэн нийт 12 хүүхэд байна. Үүнээс 6 (50.0%) эрэгтэй, 6 (50.0%) эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 8. Үрчлэлтийн үзүүлэлт, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд Үүнээс: насны бүлгээр	7	11	2	9	12
3 хүртэл	3	9	1	3	6
3-6	1	1	1	4	2
7-9	1	-	-	-	2
10 ба түүнээс дээш	2	1	-	2	2

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс



## НИЙГМИЙН ДААТГАЛ

2020 оны эхний 8 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 5363.4 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ.

Нийгмийн даатгалын сангаас 2020 оны эхний 8 сард 46565 даатгуулагч иргэнд 19338.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.

Хүснэгт 9. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт, жил бүрийн эхний VIII сард


Үзүүлэлт	2019 I-VIII		2020 I-VIII		Даатгуулагчдын тоо	
	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Тоо	Өсөлт, бууралт хувь
Нийторлого	-	6 101.02		5 363.4	-	-
Нийт зардал	43 326	16 849.7	46 565	19 338.3		
Тэтгэврийн даатгалын сан	38 554	14 297.4	42 042	16 549.4	3488↑	9.0↑
Өндөр насны тэтгэвэр	26 690	9 854.4	28 079	11 488.5	1389↑	5.2↑
Тахир дутуугийн тэтгэвэр	5 962	1 696.7	7 887	2 001.3	1925↑	32.3↑
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	2 367	667.7	2 392	756.3	25↑	1.0↑
Цэргийн тэтгэвэр	3 535	2 078.5	3 684	2 303.3	149↑	4.2↑
ҮОМШӨ-ний даатгалын сан	3 668	1 793.1	3 466	1 807.1	-202↓	-5.5↓
Тахир дутуугийн тэтгэвэр	3 285	1 683.4	3 163	1 713.0	-122↓	-3.7↓
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	217	85.2	191	82.9	-26↓	-12.0↓
Сувиллын зардал	156	15.8	108	9.7	-48↓	-30.8↓
ҮОМШӨ ХЧТА <sup>1</sup>	10	8.7	4	1.5	-6↓	-60↓
Тэтгэмжийн даатгалын сан	970	578.2	900	619.3	-70↓	-7.2↓
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	536	62.3	465	57.2	-71↓	-13.2↓
Жирэмсний амралт	314	395.8	295	422.1	-19↓	-6.0↓
Оршуулга	120	120.0	140	140.0	20↑	16.6↑
Ажилгүйдлийн даатгалын сан	134	181.1	157	362.5	23↑	17.2↑
Ажилгүйдлийн тэтгэмж	134	181.1	157	362.5	23↑	17.2↑

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

<sup>1</sup>Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан



Зураг 2. Даатгалын сангийн зарлага



Тэтгэврийн даатгалын сангаас 2020 оны эхний 8 сард тэтгэвэр авагч иргэдэд 16549.4 сая төгрөг олгосон байна. Олгосон нийт тэтгэврийн 69.4 хувийг өндөр насны, 12.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.6 хувийг тэжээгчээ алдсан, 13.9 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



### НИЙГМИЙН ХАЛАМЖ

2020 оны эхний 8 сард давхардсан тоогоор нийт 18092 хүнд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ үзүүлж, халамжийн зардлын хэмжээ өссөн дүнгээр 4417.5 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 10. Нийгмийн халамжийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2019		2020		2020% 2019	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Мөнгөн дүн (сая төгрөг)	Өсөлт, бууралт хувь
	VIII	I-VIII	VIII	I-VIII	VIII	I-VIII
Халамжийн орлого, бүгд	-	4 255.5	-	4 637.6	382.1 <sup>↑</sup>	9.0 <sup>↑</sup>
Зарцуулалт, бүгд	19201	3 997.7	18092	4 417.5	419.8 <sup>↑</sup>	10.5 <sup>↑</sup>
Халамжийн тэтгэвэр	778	1 067.2	621	1 533.4	466.2 <sup>↑</sup>	43.7 <sup>↑</sup>
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	681	315.2	725	475.4	160.2 <sup>↑</sup>	50.8 <sup>↑</sup>
Ахмад настны хөнгөлөлт	252	166.1	517	239.8	73.7 <sup>↑</sup>	44.4 <sup>↑</sup>
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	78	87.2	714	91.7	4.5 <sup>↑</sup>	5.2 <sup>↑</sup>

Хүснэгт 10-ын үргэлжлэл

Үзүүлэлт	2019		2020		2020% 2019	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Мөнгөн дүн (сая төгрөг)	Өсөлт, бууралт хувь
	VIII	I-VIII	VIII	I-VIII	VIII	I-VIII
Алдарт эхийн одонгийн тусламж	2838	366.1	2594	349.2	-16.9↓	-4.6↓
Алдар цолтой ахмад настнуудад олгосон	13	18.3	13	18.4	0.1↑	0.5↑
Хүнс тэжээл хөтөлбөрийн зардал	6339	668.4	6688	950.2	281.8↑	42.2↑
Амьжиргааг дэмжих зөвлөл	49	1.6	56	4.2	40.4↑	1.6 д↑
Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	-	-	1520	258.2	258.2↑	100.0↑
Насны хишгийн зардал	1923	270.4	1800	286.5	16.1↑	5.9↑
Цалинтай ээж хөтөлбөр	1634	640.3	2700	74.2	-566.1↓	-7.6д↓
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	461	171.3	10	14.0	-157.3↓	-11.2д↓
Өрх толгойлсон эцэг эхийн хөтөлбөр	250	70.5	130	113.2	42.7↑	60.5↑
Ихэр хүүхдийн тэтгэмж	-	-	4	8.0	8.0↑	100.0↑
Бусад зардал	-	0.8	-	0.8	-	-

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



**ЭРҮҮЛ МЭНД**

2020 оны эхний 8 сард төрсөн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 31 (5.4%), нас баралт 3 (1.7%) тус тус өссөн байна.

Хүснэгт 11.Төрөлт жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
Амаржсан эхийн тоо, бүгд	601	518	583	568	599
Амьд төрсөн хүүхэд	603	525	591	571	605
Амьгүй төрсөн	6	5	5	3	2
Эхийн эндэгдэл	-	-	-	-	1
Нас баралт	146	162	184	172	175
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	14	9	5	8	7
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	24	13	10	13	11
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	101	131	139	132	139
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт <sup>2</sup>	21	18	35	27	25

<sup>2</sup>Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

2020 оны эхний 8 сард бүртгэгдсэн нийт нас баралтын 79.4 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 14.3 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад гарсан, 6.3 хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

Хүснэгт 12. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
Нийт халдварт өвчин	707	707	340	286	283
Халдварт өвчин:	239	390	98	93	41
Хепатит В вирус	3	6	2	1	2
Хепатит С вирус	-	-	1	1	1
Менингет	-	-	-	1	1
Салхин цэцэг	49	27	14	49	13
Паротит	3	-	-	3	1
Бруцеллез	-	1	-	2	-
Ёлом	2	-	3	2	1
Дизентери	6	1	10	8	7
Гар, хөл, амны өвчин	7	40	59	16	2
Хоолны хордлого	-	6	-	-	-
Сальмонеллэз	1	2	-	1	-
Улаан бурхан	166	302	-	-	-
Улаан эсэргэнэ	-	2	6	-	6
Эритема	-	1	-	-	-
Хачигт риккеттиоз	1	2	-	1	2
Хачигт энцефалит	-	-	-	5	-
Ковид	-	-	-	-	5
Сүрьеэ	35	51	30	30	33
Арьс өнгөний өвчин	433	266	212	163	209
Тэмбүү	100	65	50	45	58
Үүнээс: төрөлхийн	1	1	-	-	-
Заг хүйтэн	35	31	58	42	52
Хамуу	2	-	-	-	-
Бэлгийн замын мөөгөнцөр	211	69	65	33	54
Мөөгөнцөр	26	4	7	-	-
Трихомониаз	59	97	32	43	45

Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд хурц халдварт өвчнөөр 41 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52 (55.9%) хүнээр бүүрч, арьс өнгөний өвчлөл 209 гарсан нь 46 (28.2%) хүнээр өссөн байна. Сүрьеэгээр 33 хүн өвчилсөн нь 3 (10.0%) өмнөх оны мөн үеэс өссөн байна. Нийт халдварт өвчний гаралт 283 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3 (1.0%) буурсан байна.

Хүснэгт 13. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
Урьдчилан сэргийлэх тарилга	4201	4169	3837	4255	4535
Амбулаторын үзлэг	128171	126200	131067	139755	132278
Ор хоног	31389	32615	34506	37036	32568
Эмчийн тоо	69	68	75	78	76
Сувилагчийн тоо	104	95	98	105	108
Орны тоо	177	177	227	227	227

Зураг 3. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт



Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 7477 (5.3%), ор хоног 4468 (12.1%) тус тус буурсан байна. Урьдчилан сэргийлэх тарилга 280 (6.6%) өссөн байна.



### СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2020 оны эхний 8 сард нийтдээ 5 төрлийн 25 ажил, үйлчилгээг явуулж, 4855.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Хүснэгт 14. Соёл, урлагийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, 2019 оны эхний V сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс:					Номын сан (уншигчид)	Музейн <sup>3</sup> үзэгчид
		Урлагийн тоглолт	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	25	2	16	6	1	6	69	-

Эх үүсвэр : Соёл урлагийн ордон

<sup>3</sup> Орон нутаг судлах танхим



## АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2020 оны эхний 8 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 192.4 сая төгрөг болж, орлогын 34.5 хувийг орон сууц, 42.0 хувийг гэр хороолол, 23.5 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 14.5 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

Хүснэгт 15. Хот тохижилтын үзүүлэлт, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	Үүнээс:		
				Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого, сая төгрөг	163.7	177.4	192.4	66.3	80.8	45.3
Хог тээвэрлэлт, мянган тонн	54.7	31.6	14.5	4.9	6.2	3.2

Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

Хүснэгт 16. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
Шахсан ус	мянган м <sup>3</sup>	652.5	630.6	654.9	536.0
Борлуулсан ус	мянган м <sup>3</sup>	239.7	266.2	605.5	315.7
Үүнээс: Хүн амд	мянган м <sup>3</sup>	180.3	175.0	376.0	213.3
Аж ахуйн нэгж байгууллагад	мянган м <sup>3</sup>	95.1	91.2	229.5	102.4
Татан зайлуулсан бохир	мянган м <sup>3</sup>	221.7	256.3	440.6	236.3
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	265.4	318.5	824.3	454.1
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	172.1	231.9	494.4	245.2
Халаалтын орлого	сая төгрөг	58.7	39.5	204.2	132.5

Эх үүсвэр: Чандмань Налайх ОНӨААТҮГазар

2020 оны эхний VIII сард дүүргийн хэмжээнд 315.7 мянган м<sup>3</sup> ус борлуулснаас, 213.3 мянган м<sup>3</sup> (67.6%) усыг хүн амд, 102.4 мян.м<sup>3</sup> (37.9%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.

## ГЭМТ ХЭРЭГ



Дүүрэгт 2020 оны эхний VIII сард 251 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 гэмт хэргээр (5.5%) өсч, гэмт хэргийн илрүүлэлт 41.7 хувьтай байна.


Бүртгэгдсэн гэмт хэрэгт 140 сэжигтэн яллагдагч холбогдсон бөгөөд насны ангиллаар авч үзвэл 15 хүртэл насны 1 (0.7), 16-17 насны 3 (2.1), 18-24 насны 33 (23.6), 25-29 насны 24 (17.1), 30-34 насны 21 (15.0), 35-39 насны 20 (14.3), 40-44 насны 16 (11.4), 45-49 насны 7 (5.0), 50-54 насны 9 (6.5), 55-59 насны 2 (1.4), 60-64 насны 4 (2.9) иргэд байна.

Хүснэгт 17. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	298	313	238	251
Хүн амины				
Санаатай	2	2	3	3
Учрал	13	4	14	3
Бусдыг болгоомжгүй алах	-	-	-	-
Хүчин	1	3	4	3
Дээрэм	2	6	1	2
Танхай	19	-	-	-
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	-	3	3	5
Хулгай				
Иргэдийн өмчийн	84	116	65	51
Малын	7	8	10	11
Халаасны хулгай	-	1	1	1
Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн	4	5	-	-
Автомашины	-	1	1	2
Залилан	10	11	16	27
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан	106	106	86	123
Авто тээвэр	16	18	16	9
Бусад	34	29	18	11
Илрүүлээгүй гэмт хэргийн тоо	119	191	130	123
Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь	31.2	34.6	40.4	41.7
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд	184	123	103	140
Үүнээс:				
Ажилгүй	136	66	76	114
Албан хаагч	6	14	2	3
Сурагч	4	-	5	1
Оюутан	2	6	-	4
Малчин	2	-	1	-
Төрийн бус байгууллагын ажилтан	1	7	3	3
Хугацаат цэргийн алба хаагч	1	-	-	-
ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч	32	30	16	12
Хоригдол	-	-	-	3
Эрүүлжүүлэгдсэн хүн	1893	2062	1849	2778

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтэс

Зураг 4. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороодоор



иргэнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулжээ.

Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 129 хүн гэмтэж бэртсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 787.6 сая төгрөгийн хохирол учруулсны 416.6 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна. 2020 оны эхний 8 сард 23868 зөрчил илрүүлж, 23861 хүн, 7 хуулийн этгээдийг 745.6 сая төгрөгөөр торгож, 2778 (эмэгтэй 374) иргэнийг эрүүлжүүлж, 412 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 102



## ТӨСӨВ

2020 оны эхний 8 сард дүүргийн төсөвт 1520.6 сая төгрөгийн татварын орлого төвлөрч, төлөвлөгөө 236.6 сая төгрөгөөр (13.5%) тасарсан биелэв.

Татварын орлогын 37.8 хувийг хүн амын орлогын албан татвар, 12.7 хувийг хог хаягдлын үйлчилгээний хураамж, 0.3 хувийг бууны татвар, 0.1 хувийг ус, рашаан ашигласны төлбөр, 5.4 хувийг түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, 5.8 хувийг улсын тэмдэгтийн хураамжийн орлого, 3.2 хувийг хүү торгуулийн орлого, 31.9 хувийг Татварын бус торгуулийн орлого, 2.8 хувийг газрын орлого тус тус бүрдүүлсэн байна.



Эх үүсвэр: Татварын хэлтэс



## ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс тэмээний шир 20000 төгрөгөөр 1.3 дахин, адууны шир 2000 төгрөгөөр (20%)-иар өссөн, үхрийн шир (33.3%)-иар буурсан, ямааны арьсны үнэ өмнөх оны мөн үетэй адил байна.

Хүснэгт 18. Зарим түүхий эдийн үнэ, жил бүрийн эхний VIII сард


Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	2016 VIII	2017 VIII	2018 VIII	2019 VIII	2020 VIII
		төгрөг				
Тэмээний шир	ширхэг	15000	18000	10000	15000	35000
Адууны шир	ширхэг	30000	14000	10000	10000	12000
Адууны дэл	кг	5000	-	11000	5000	7000
Адууны сүүл	кг	7000	-	12000	10000	12000
Үхрийн шир (дундаж үнэ)	1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	21500	29000	15000	15000	10000
Хонины арьс	ширхэг	2000	4000	3000	-	-
Ямааны арьс (ноолуургүй)	ширхэг	-	1500	1500	1500	1500
Ямааны ноолуур	кг	-	38000	80000	-	-

Хүснэгт 19. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2019.VIII.31					2020.IX.10				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	1600	1760	2300	-	-	1300	1370	1850	-
Петровис	2240	1750	1840	2370	-	2000	1350	1450	2090	-
Магнай трейд	2240	-	1840	2350	-	2000	-	1450	2090	-
Сод монгол	2240	-	1840	2360	-	2000	-	1450	2090	-
Шунхлай	2240	-	1840	2350	-	2000	-	1450	2090	-
Юнигаз	-	-	-	-	1300	-	-	-	-	970
Дундаж үнэ	2240	1675	1824	2346	1300	2000	1325	1434	2042	970

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

Зураг 6. Нэг литр шатахууны дундаж үнэ VIII сард



### МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО



Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа холбооны байгууллага 181.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үүнээс 88.7 сая төгрөг (49.0%) нь хүн амд үзүүлсэн үйлчилгээний орлого эзэлж байна.

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 105 (16.7%) өссөн байна. Нийт суурин телефон цэгийн 455 (62.2%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 187 (25.6%) нь төсвийн байгууллагад, 89 (12.2%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.



Хүснэгт 21. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
Нийт орлого	сая төгрөг	136.8	163.1	148.0	181.0
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний	сая төгрөг	65.7	79.9	72.5	88.7
Телефон цэг	тоо	587	597	626	731
Үүнээс: айл өрх	тоо	343	337	355	457
Интернет үйлчилгээний цэг	тоо	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал	тоо	20	20	20	20
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид	тоо	9440	5663	2648	550
Интернетийн байнгын хэрэглэгчид	тоо	472	397	556	189
Таксофон	тоо	1	1	1	1

Хүснэгт 22. Кабелийн телевизийн үзүүлэлт, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт/он	хэмжих нэгж	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
КТВ-ийн орлого	мян.төг	87 483.0	87 483.0	45 603.0	39 537.7
Хэрэглэгч	тоо	3 575	3 575	1 235	1 100

2020 оны эхний 8 сард дүүргийн Засаг даргын 38 удаагийн захирамжаар нийт 2102 иргэн, 41 аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 23. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, жил бүрийн эхний VIII сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил өөрчлөх	Газар ашиглуулах эрх олгох
Иргэн, ААНБ-ын тоо	10	8	1682	384	-	-	24	35

Эхүүсвэр: Газар зохион байгуулалтын алба



## АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс 2020 оны эхний 8 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж нийт 319 айл өрх, 200 аж ахуйн нэгж, байгууллагад зөрчил илрүүлэн, 397 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 46, мэдэгдэл 72, зөрчлийн тэмдэглэл 15, дүгнэлт 14, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 104, танилцуулга 9, шинжээч мэргэжилтний дүгнэлт 5, гал түймэр унтраасан нотломж 34, гал түймэр гаргасан тухай акт 5, хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 34 дуудлагаар ажиллаж, 614.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хүснэгт 24. Гал түймрийн дуудлагын тоо жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
<b>Бүгд</b>		<b>62</b>	<b>59</b>	<b>37</b>	<b>34</b>
<b>Өмчийн хэлбэрээр:</b>					
Төрийн өмч	тоо	5	5	2	-
Хувийн өмч	тоо	49	54	33	33
Аж ахуйн нэгж	тоо	8	-	2	1
Хамтын болон гадаад улсын өмч	тоо	-	-	-	-
<b>Гал түймэрт өртөж шатсан:</b>					
Нас барсан	хүүхэд том хүн	- -	1 2	- -	- -
Түлэгдэж бэртсэн	хүүхэд том хүн	- -	- 1	- -	- -
Өвөл зуны сууц	тоо	6	12	4	14
Гэр	тоо	11	10	1	4
Хог, хогийн суваг	тоо	12	15	8	4
Машин техник	тоо	7	3	3	7
Барилга байгууламж	тоо	1	3	4	1
Малын хашаа саравч	тоо	4	1	3	-
Бусад	тоо	-	-	-	4
<b>Шалтгаан:</b>					
Цахилгааны	тоо	2	3	1	6
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	5	-	4	2
Лаа, тамхи, шүдэнз	тоо	1	16	3	-
Пийшин зуухны цоолт	тоо	2	-	-	1
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	3	1	-	1
Машин, техникийн яндангийн оч болон цахилгааны очноос	тоо	-	-	-	2
Архидан согтуурснаас	тоо	2	2	-	2
Газрын тосны бүтээгдэхүүний ашиглалтын буруугаас	тоо	1	-	-	-
Бусад	тоо	5	-	1	1
Шалтгаан тогтоогдоогүй	тоо	41	37	28	10
<b>Аварсан эд хөрөнгө:</b>					
Хүн	тоо	-	1	-	4
Өвөл зуны сууц	тоо	7	6	4	8
Гэр	тоо	1	4	1	3
Барилга байгууламж	тоо	1	5	2	5
Машин техник	тоо	2	2	1	3
Улсын онц чухал болон галын онц аюултай объект	тоо	-	1	-	1
Малын хашаа саравч	тоо	-	-	-	-
Эд хөрөнгө	сая төгрөг	1139.0	323.0	225.6	614.0

Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс



## ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, [www.ub1200.mn](http://www.ub1200.mn) цахим хуудас, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2020 оны эхний 8 сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 1183 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 1217 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, 34-д хариу өгөх хугацаа болоогүй болон судлагдаж байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 97.0 хувьтай байна. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 1153 (95.8%) нь бичгээр, 64 (4.2%) нь утсаар ирсэн байна.

Эх үүсвэр: ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк :  
[www.ubstat.mn](http://www.ubstat.mn)

Налайх дүүргийн Статистикийн  
хэлтэс facebook page

Утас: 7023-3672

УБ хот, Налайх дүүрэг ЗДТГ-ын байр 2 давхар 210 тоот